



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/441

Мөрөн сум

Жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 20 дугаар зүйлийн 20.1.16, Хог хаягдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5, 8 дугаар зүйлийн 8.1.14, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А-429/257 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

“Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

Жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн татаж, дахивар нөөцийн цэгт өөрийн хөрөнгөөр хүргүүлэхийг даалгасугай.


Захирамжийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Улам-Өсөх) Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (П.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 09
дугаар сарын 15-ний өдрийн А/44/1
дугаар захирамжийн хавсралт



ҮҮСЭХ ХОГ ХАЯГДЛЫГ ҮЙЛДВЭРЛЭГЧ БОЛОН ИМПОРТЛОГЧ ХАРИУЦАХ ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

Дараах үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах үйл ажиллагааг хариуцна.Үүнд:

1. Хуванцар сав суулга, түүхий эд;
2. Нийллэг уут түүний түүхий эд ;
3. Бүх төрлийн зай хураагуур, аккумулятор;
4. Хими цэвэрлэгээний бодис
5. Шилэн лонх сав
6. Өндөр даралтат сав
7. Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол
8. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн сэлбэг хэрэгсэл, дугуй
9. Бүх төрлийн машин механизмын тос, тосолгооний бүтээгдэхүүн
10. Мөнгөн ус агуулсан бараа бүтээгдэхүүн
11. Аюултай хог хаягдал

_____оОо_____